

## Монгол домэйн нэрийн бүртгэлийн журам

1. Ерөнхий зүйл
2. Бүртгэгч, хэрэглэгчийн эрх ба үүрэг
3. Домэйн нэр бүртгэх
4. Бүртгэлийн хугацааг сунгах
5. Домэйн нэр шилжүүлэх
6. Домэйн нэрийн үйлчилгээг түдгэлзүүлэх, цуцлах
7. Эзэмшигчийн мэдээлэл, WHOIS
8. Нууцлал
9. Домэйн нэрийн маргаан
10. Журмын өөрчлөлт

### 1. Ерөнхий зүйл

- 1.1. Монгол домэйн нэрийн бүртгэлийн журам (цаашид “Журам” гэх) нь Монгол кирилл үсгээр домэйн нэр бүртгэхтэй холбоотойгоор Зохицуулагч, Итгэмжлэгдсэн бүртгэгч, Хэрэглэгч нарын хоорондын харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Журамд ашиглагдах нэр томъёо:
  - Монгол домэйн нэр** - .МОН хэмээх нэршилтэй дээд түвшний домэйн нэр. Монгол домэйн нэр нь кирилл цагаан толгойн 35 үсэг (а-я), тэгээс ес хүртэл тоо (0-9), "зураас" (-) аас бүрдэнэ.
  - Кирилл домэйн нэр** - латин үсэг, тоо цифр, зураас, тэмдэглэгээ агуулсан домэйн нэрийг (RFC-3490, 3491, 3492 техникийн стандартад заасан) PUNYCODE алгоритмын дагуу хувиргалтын үр дүнд гарах кирилл домэйн нэр;
  - Зохицуулагч** - Монгол домэйн нэрийн бүртгэлийн үйлчилгээ, удирдлагыг гүйцэтгэх бүрэн эрхт итгэмжлэгдсэн хуулийн этгээд - Датаком ХХК;
  - Итгэмжлэгдсэн бүртгэгч** - монгол домэйн нэрийн бүртгэлийн үйлчилгээ үзүүлэхийн тулд Зохицуулагчийн магадлан итгэмжилсэн хуулийн этгээд;
  - Хэрэглэгч** - домэйн нэр бүртгүүлэх үйлчилгээ авахаар Зохицуулагч болон Итгэмжлэгдсэн бүртгэгчид хандсан хуулийн этгээд буюу хувь хүн;
  - Бүртгэгч** - домэйн нэрийн бүртгэх эрх бүхий Зохицуулагч ба Итгэмжлэгдсэн бүртгэгч;
  - Бүртгэлийн сан** - монгол домэйн нэрийн бүртгэл ба эзэмшигчийн мэдээллийг агуулсан мэдээллийн сан;
  - Хүсэлт** - Хэрэглэгч эсвэл итгэмжлэгдсэн бүртгэгч, зохицуулагч нарын хооронд домэйн нэрийн бүртгэлийн үйлчилгээний мэдээлэл өөрчлөх, үйлчилгээ шинэчлэх, цуцлах зэрэг шаардлагатай мэдээлэл агуулсан хүсэлт;
  - Бүртгэл цуцлах** - бүртгэлийн мэдээллийн сангаас домэйн нэрийн мэдээллийг устгах;
  - Бүртгэлийн хугацааг сунгах** - домэйн нэрийн бүртгэлийн хугацааг сунгах тухай мэдээллийг бүртгэлд оруулах;
  - DNS/домэйн нэрийн системийн үйлчилгээ** - Интернэтэд тавигдах техникийн шаардлагын дагуу домэйн нэрийн тухай холбогдох мэдээллийг агуулсан тоног төхөөрөмж, програм хангамжийн систем;
  - WHOIS** - админ болон бүртгэгдсэн домэйн нэрийн тухай эзэмшигчийн мэдээллийг агуулсан нээлттэй сан;
- 1.3. Домэйн нэрийн бүртгэлийн нөхцөл нь Журам, Итгэмжлэгдсэн бүртгэгч ба Хэрэглэгчийн хооронд байгуулсан үйлчилгээний гэрээгээр тодорхойлогдоно. Домэйн нэрийн бүртгэлийн үйлчилгээний эрхийг дараах хувь хүн, хуулийн этгээд эдэлнэ. Үүнд:
  - Монгол Улсын 16 нас хүрсэн иргэн буюу хувь хүн;
  - Монгол Улсын хууль, журмын дагуу бүртгэгдсэн хуулийн этгээд;

- Монгол Улсын хууль, журмын дагуу тус улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын хуулийн этгээд.
- 1.4. Домэйн нэрийн бүртгэлийн үйлчилгээний гэрээ нь Бүртгэгч ба Хэрэглэгчийн хооронд байгуулагдах ба үйлчилгээтэй холбоотой эрх, үүргийг тодорхойлно. Энэхүү үйлчилгээний гэрээ нь нийтэд нээлттэй байна.
- 1.5. Аливаа хүсэлт нь монгол домэйн нэрийн бүртгэлийн санд бүртгэгдсэн цахим шуудангийн хаягаар хэрэглэгчдэд илгээгдэнэ.
- 1.6. Итгэмжлэгдсэн бүртгэгч нь домэйн нэрийн бүртгэлийн үйлчилгээгээ зогсоосон тохиолдолд домэйн нэрийн үйлчилгээг Зохицуулагч шилжүүлэн авна. Зохицуулагч нь Итгэмжлэгдсэн бүртгэгчийн домэйн нэрийн бүртгэлийн үйлчилгээ зогссон бол хэрэглэгчдэд мэдээлнэ.

## **2. Бүртгэгч, хэрэглэгчийн эрх ба үүрэг**

- 2.1. Бүртгэгч нь дараах үүрэгтэй:
  - 2.1.1. Журмыг чандлан дагах;
  - 2.1.2. Хэрэглэгчтэй домэйн бүртгэлийн үйлчилгээний гэрээ байгуулах
  - 2.1.3. Домэйн нэрийн бүртгэлийн үйлчилгээг захиалсан ямар ч хувь хүн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, тэгш эрхтэй үйлчлэх;
  - 2.1.4. Домэйн нэрийн бүртгэлийн үйлчилгээний гэрээ байгуулахдаа хэрэглэгчид журмыг танилцуулах;
  - 2.1.5. Хэрэглэгчийн хүсэлтийг Журмын дагуу болон заасан хугацаанд биелүүлэх;
  - 2.1.6. Хэрэглэгчдэд Журамд заасан тохиолдолд болон заасан хугацаанд мэдэгдэл илгээнэ.
  - 2.1.7. Бүртгэгч нь зохицуулагчийн батласан үнийн саналын дагуу хоорондын төлбөр тооцоог хийнэ;
- 2.2. Итгэмжлэгдсэн бүртгэгч дараах эрхтэй:
  - 2.2.1. Төлбөр тарифыг тогтоох;
  - 2.2.2. Журамд заасан хэрэглэгч болон админы харилцан хамтран ажиллах бусад нөхцлийг тодорхойлох;
- 2.3. Итгэмжлэгдсэн бүртгэгч нь Хэрэглэгчийн өмнө зөвхөн бүртгэлийн үйл явцаас гарах үйлдлүүдэд хариуцлага хүлээнэ.
- 2.4. Итгэмжлэгдсэн бүртгэгч нь Интернэтийн техникийн асуудал болон Итгэмжлэгдсэн бүртгэгчийн мэдлээс гадуурх үйл ажиллагаанаас болж домэйн нэрийн систем хэвийн ажиллагаа алдагдахад хариуцлага хүлээхгүй.
- 2.5. Хэрэглэгч дараах үүрэгтэй:
  - 2.5.1. Журам болон Итгэмжлэгдсэн бүртгэгчтэй байгуулсан домэйн нэрийн бүртгэлийн үйлчилгээний гэрээний заалтуудыг мөрдөх;
  - 2.5.2. Журмын 7 дугаар бүлэгт заасны дагуу эзэмшигчийг гэрчлэх, үнэн зөв мэдээлэл өгөх;
- 2.6. Хэрэглэгч нь монгол домэйн нэрийн сонголт, домэйн нэрийн бүртгэлтэй холбоотой гуравдагч этгээдийн эрхийг зөрчих, уг зөрчилтэй холбоотой гарч болох болзошгүй хохиролд хариуцлага хүлээнэ. Ийм төрлийн зөрчил гаргахгүйн тулд Хэрэглэгч домэйн нэрээ бүртгүүлэхдээ алдартай брэнд болон ижил барааны тэмдэгт, байгууллагын нэр, оюуны өмчийн бусад объектын нэр нэршил давхардуулж сонгохгүй байх үүрэгтэй.
- 2.7. Хэрэглэгч нь домэйн нэр бүртгэлийн үйлчилгээний гэрээг аль ч Итгэмжлэгдсэн бүртгэгчтэй байгуулах эрхтэй.

## **3. Домэйн нэр бүртгэх**

- 3.1. Зохицуулагч эсвэл Итгэмжлэгдсэн бүртгэгчтэй байгуулсан Домэйн нэрийн бүртгэлийн гэрээний дагуу хэрэглэгчийн хүсэлтээр домэйн нэрийг бүртгэнэ.
- 3.2. Домэйн нэр бүртгэх үйлчилгээ нь нийтэд нээлттэй бөгөөд бүртгүүлэгч бүр тэгш эрхтэйгээр, хэн түрүүлж хүсэлт гаргасан нь эхэлж бүртгүүлэх зарчмаар явагдана.

- 3.3. Домэйн нэр бүртгүүлэх үйлчилгээг төлбөр төлөгдсөнөөс хойш ажлын 8 цагийн дотор шийдвэрлэнэ.
- 3.4. Домэйн нэрийг дараах тохиолдолд бүртгэж болно:
- 3.4.1. Домэйн нэр бүртгэхэд чөлөөтэй байх. Үүнд:
- 3.4.1.1. уг домэйн нэр мэдээллийн санд бүртгэгдээгүй байх;
- 3.4.1.2. уг нэр нь нөөц домэйн нэрнүүдийн жагсаалтанд ороогүй байх (Журмын 3.6 заалт);
- 3.4.1.3. домэйн нэрэнд нийгмийн сонирхол, хүн чанар болон ёс суртахуунд нийцэхгүй (тухайлбал хүн болон шашны үзэл бодол доромжилсон г.м) хориотой үг хэллэг ашиглахыг хориглоно.
- 3.4.2. домэйн нэр нь дараах техникийн шаардлагад нийцэх ёстой:
- 3.4.2.1. домэйн нэрийн ерөнхий бүртгэл нь хамгийн багадаа 3 тэмдэгтээс бүтнэ (“.мон” өргөтгөлийг оруулахгүйгээр). 2 тэмдэгтээс бүтсэн домэйн нэрийн бүртгэлийг Тусгай бүртгэлийн журмаар<sup>1</sup> зохицуулна. Домэйн нэр нь хамгийн ихдээ 63 тэмдэгтээс бүтсэн байна. (“.мон” тэмдэгтүүдийг оруулахгүйгээр);
- 3.4.2.2. домэйн нэрний эхлэл ба төгсгөл кирилл цагаан толгойн үсэг эсвэл тоо байна;
- 3.4.2.3. завсрын тэмдэгтүүд нь кирилл цагаан толгойн үсэг, тоо эсвэл дундуур зураас байна. Кирилл цагаан толгойн боломжит тэмдэгтүүд нь UTF-8 тэмдэгтүүдийн “а” үсгээс “я” үсэг хүртэл байна. UTF-8 бүх тэмдэгтүүд нь <http://www.unicode.org/charts/PDF/U0400.pdf> хаягийн дагуу байна.
- 3.5. Мэдээллийн санд итгэмжлэгдсэн бүртгэгчийн болон хэрэглэгчийн мэдээллийг оруулж, төлбөр хийгдсэнээс хойш домэйн нэр бүртгэгдсэн гэж үзнэ.
- 3.6. Бусад домэйн нэрний ашиглалт болон бүртгэлийн дүрэм нь зохицуулагчаар (нөөц домэйн нэрнүүд) заагдана. Нөөц домэйн нэрсд дараах домэйн нэрс багтана:
- Улсын хэрэглээний домэйн нэр (улсын болон төрийн байгууллагын нэрэнд харгалзах домэйн нэрс) ;
  - Газарзүйн хэрэглээний домэйн нэр (Монгол улсын субъектуудын нийслэл болон Монгол Улсын аймгийн төв, хотуудын нэрсд харгалзах домэйн нэрс);
  - Оюуны өмч болон барааны тэмдгийн гэрчилгээ эзэмшигчдийн домэйн нэрс;
  - Зохицуулагчийн хэрэглээний домэйн нэр (.мон домэйныг зохицуулагчаар удирдахад шаардлагатай домэйн нэрс).
  - 2 тэмдэгт бүхий тусгай бүртгэлийн домэйн нэр
- 3.7. Дараах тохиолдлуудад Зохицуулагч болон Итгэмжлэгдсэн бүртгэгч нь домэйн нэр бүртгэхээс татгалзах эрхтэй:
- 3.7.1. хэрэглэгчийн сонгосон домэйн нэр Журмын 3.4,-ын заалтын шаардлагад нийцээгүй;
- 3.7.2. Журмын 7.3, 7.4 заалтуудын дагуу хэрэглэгчийн гаргаж өгсөн мэдээлэл нь бүрэн гүйцэд бус эсвэл үнэн бус тохиолдолд;
- 3.7.3. Хэрэглэгчтэй байгуулсан домэйн нэрийн бүртгэлийн үйлчилгээний гэрээний заалтуудыг биелүүлээгүй эсвэл журмыг мөрдөөгүй тохиолдолд.
- 3.7.4. Тухайн эзэмшигчийн эзэмшиж буй .мон домэйн нэртэй холбоотой шийдвэр гаргах эрх бүхий байгууллагаас ирүүлсэн албан шийдвэр, шүүхийн шийдвэр, тогтоол, Монгол улсын хууль тогтоомжинд заасан хэм хэмжээг зөрчсөн нь нотлогдсон тохиолдолд.
- 3.8. Бүртгэгч нь Хэрэглэгчид домэйн нэрийг нь бүртгэхээс татгалзсан хариуг бичгэн хэлбэрээр өгнө.

#### 4. Бүртгэлийн хугацааг сунгах дүрэм

- 4.1. Домэйн нэрийн бүртгэлийн хугацаа нь төлбөрийн нөхцлөөс хамааран 3, 5, 10 жил байна.
- 4.2. Бүртгэгч нь бүртгэлийн хугацаа дууссан огноогоос домэйн нэрийн бүртгэлийг 4.1-д зааснаар хязгааргүй олон удаа сунгах эрхтэй.

<sup>1</sup> Датаком ХХК-ийн Тусгай тэмдэгт бүхий домэйн нэрийн журмыг баримтална.

- 4.3. Домэйн нэрийн хугацааг сунгах шаардлагатай тухай мэдэгдлийг хэрэглэгчид бүртгэлийн хугацаа дуусахаас 30 (гуч)-аас багагүй хоногийн дотор бүртгэгдсэн цахим шуудангийн хаягаар мэдэгдэнэ.
- 4.4. Домэйн нэрийн үйлчилгээний хугацаа дууссанаас хойш уг домэйн нэр 30 хоногийн хугацаанд идэвхгүй горимд шилжих ба энэ хугацаанд хэрэглэгч төлбөрөө төлж сунгах боломжтой. Төлбөр хийгдээгүй тохиолдолд домэйн нэрийн бүртгэл цуцлагдаж, нийтэд нээлттэй болно.

## **5. Домэйн нэр шилжүүлэх**

- 5.1. Хэрэглэгч нь домэйн нэрийг өөр хүнд болон өөр Бүртгэгчид шилжүүлж болно.
- 5.2. Сонгосон бүртгэгч нь Домэйн нэрийн бүртгэл энэхүү дүрмийн 3.4 дүгээр заалтад харшлахгүй гэж үзсэн бол домэйн нэрийн талаарх мэдээлэл шилжиж байгаа Бүртгэгчийн хувьд хүлээн авахаас татгалзах эрхгүй.
- 5.3. Домэйн нэрийн мэдээллийг шилжүүлэхдээ:
  - 5.3.1. Хэрэглэгч домэйн нэрийн бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх тухай гэрээг сонгогдсон Итгэмжлэгдсэн бүртгэгчтэй шинээр хийнэ;
  - 5.3.2. Хэрэглэгч нь домэйн нэрийн талаарх мэдээллийг шилжүүлэх хүсэлтийг одоогийн Итгэмжлэгдсэн бүртгэгчид хувь хүн и-мэйлээр, албан байгууллага албан бичгээр ирүүлнэ;
  - 5.3.3. Одоогийн Итгэмжлэгдсэн бүртгэгч нь домэйн шилжүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын гурав (3) хоногийн дотор шаардлагатай арга хэмжээг авч, асуудлыг шийдвэрлэнэ;
  - 5.3.4. Домэйн нэрийг хүлээн авч байгаа Итгэмжлэгдсэн бүртгэгч холбогдох мэдээллийг бүртгэлийн санд үнэн зөвөөр оруулах ёстой.
- 5.4. Эзэмшигчийн мэдээллийг бүртгэлийн санд оруулж шинэчилсэн өдрөөс эхлэн домэйн нэр шилжсэн гэж үзнэ.
- 5.5. Хэрэглэгч дараах нөхцлүүдэд хуанлийн жаран (60) хоногийн дотор Домэйн нэрийг өөр этгээдэд шилжүүлж болохгүй: Үүнд:
  - 5.6.1 өөр хэрэглэгчээс домэйн нэр шилжүүлж авсан өдрөөс хойш;
  - 5.6.2 домэйн нэрийг өөр Итгэмжлэгдсэн бүртгэгчээс шилжүүлсэн өдрөөс хойш;
- 5.6. Домэйн нэр шилжүүлэн авсан хэрэглэгч нь тухайн домэйн нэрийн сунгалтын төлбөрийг өмнө бүртгэсэн хугацааг харгалзалгүйгээр, шинээр тооцон 4.1-д заасан нөхцлөөр бүртгүүлж төлбөрийг төлнө.

## **6. Домэйн нэрийн үйлчилгээг түдгэлзүүлэх, цуцлах**

- 6.1. Бүртгэгч нь домэйн нэрийн бүртгэлийг дараах тохиолдолд түдгэлзүүлэх эсвэл цуцлах эрхтэй:
  - 6.1.1. Монгол улсын хууль тогтоомжийг зөрчсөн нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон бол;
  - 6.1.2. Энэхүү журмын 7.3, 7.4-р зүйлд заасны дагуу зайлшгүй шаардлагатай мэдээллийг өгөхдөө хэрэглэгч дутуу буюу бүрэн бус, худал мэдээллээр хангасан;
  - 6.1.3. Итгэмжлэгдсэн бүртгэгч төлбөр тооцооны асуудалтай бол;
  - 6.1.4. Домэйн нэрийн эзэмшигчийн талаар маргаан үүссэн тохиолдолд;
  - 6.1.5. Хүчин төгөлдөр шүүхийн актын (шийдвэрийн) дагуу;

## **7. Эзэмшигчийн бүртгэл**

- 7.1. Домэйн нэрийн эзэмшигчийн ерөнхий мэдээлэл нь WHOIS зарчмаар олон нийтэд нээлттэй байна.
- 7.2. Бүртгэгч нь эзэмшигчийн бүртгүүлсэн домэйн нэрийг нь нийтэд зарлах эрхтэй.
- 7.3. Хувь хүн нь домэйн нэрийн бүртгэлийн үйлчилгээний гэрээг байгуулахдаа Бүртгэгчид дараах мэдээллийг үнэн зөвөөр гаргаж өгнө:
  - 7.3.1. Эзэмшигчийн мэдээлэл:

- 7.3.1.1. овог, нэр;
  - 7.3.1.2. төрсөн он сар өдөр (нийтэд ил харагдахгүй);
  - 7.3.1.3. регистрийн дугаар (нийтэд ил харагдахгүй);
  - 7.3.1.4. оршин суугаа хаяг;
  - 7.3.1.5. шуудангийн хаяг;
  - 7.3.1.6. телефон утас, факсын дугаар;
  - 7.3.1.7. и-мэйл хаяг
- 7.4. Байгууллагын хэрэглэгч нь домэйн нэрийн үйлчилгээний гэрээг байгуулахдаа Итгэмжлэгдсэн бүртгэгчид дараах мэдээллийг бүрдүүлж өгнө:
- 7.4.1. Эзэмшигчийг тодорхойлох шаардлагатай мэдээлэл:
    - 7.4.1.1. Байгууллагын нэр
    - 7.4.1.2. Захирлын овог, нэр;
    - 7.4.1.3. Байгууллагын албан ёсны хаяг, байршил ;
    - 7.4.1.4. Байгууллагын улсын бүртгэлийн дугаар
    - 7.4.1.5. Утас, факсын дугаар ;
    - 7.4.1.6. И-мэйл хаяг.
  - 7.4.2. Мэдээллийн Технологийн мэргэжилтний мэдээлэл:
    - 7.4.2.1. Байгууллагын нэр
    - 7.4.2.2. Овог, нэр;
    - 7.4.2.3. Гар утас, ажлын утас:
    - 7.4.2.4. Факсын дугаар ;
    - 7.4.2.5. И-мэйл хаяг.
    - 7.4.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
  - 7.4.3. Монгол Улс дахь гадаадын хуулийн этгээдийн бие даасан салбарыг магадлан итгэмжлэлийг баталгаажуулсан баримт бичгийн хуулбар
  - 7.4.4. Байгууллагын хэрэглэгчийн хувьд 7.4.2-д заасны дагуу бүртгэгдсэн мэргэжилтэн нь домэйн нэрийг хүчингүй болгох, шилжүүлэх, эзэмшигчийг бүртгэлд хадгалагдаж буй мэдээлэлд өөрчлөлт оруулах эрхгүй эрхгүй.
- 7.5. Бүртгэгч нь домэйн нэрийн бүртгэлийн үйлчилгээний гэрээний хүчинтэй хугацаанд байгууллагын хэрэглэгчийн бичиг баримтын хуулбарыг хадгална.
- 7.6. WHOIS үйлчилгээгээр дамжуулан, бүртгэлд агуулагдаж буй домэйн нэрийн тухай дараах мэдээллийг авах боломжтой. Үүнд:
- 7.6.1. Кирилл домэйн нэр;
  - 7.6.2. Эзэмшигчийн мэдээлэл
    - 7.6.2.1. Байгууллагын нэр;
    - 7.6.2.2. Удирдлагын овог, нэр;
    - 7.6.2.3. Байгууллагын албан ёсны хаяг, байршил;
    - 7.6.2.5. Утас, факсын дугаар;
    - 7.6.2.6. И-мэйл хаяг.
  - 7.6.3. Мэдээллийн Технологийн мэргэжилтний мэдээлэл:
    - 7.6.3.1. Байгууллагын нэр
    - 7.6.3.2. Овог, нэр;
    - 7.6.3.3. Гар утас, ажлын утас:
    - 7.6.3.4. Факсын дугаар ;
    - 7.6.3.5. И-мэйл хаяг.
  - 7.6.4. DNS домэйн серверийн хаяг, нэр;
  - 7.6.5. Бүртгэсэн огноо
  - 7.6.6. Бүртгэлийн хугацаа дуусах огноо
  - 7.6.7. Бүртгэгчийн нэр, дугаар

## 8. Нууцлал

- 8.1. Монгол Улсад одоо мөрдөгдөж буй хууль тогтоомж, домэйн нэр бүртгэлийн үйлчилгээний гэрээнд өөрөөр заагаагүй бол энэхүү журмын 9.4.1.2, 9.4.1.3, 9.5.1.4, 9.5.3-д заасан бүртгэлийн санд хадгалагдаж буй мэдээлэл нууцлалд хамаарна.
- 8.2. Бүртгэгч нь нууц мэдээллийг зөвхөн дараах тохиолдолд хүсэлтийн дагуу гаргаж өгч болно:
  - 8.2.1. Төрийн захиргаа, эрх бүхий байгууллага болон шүүх хууль тогтоох байгууллагын хүсэлтээр;
  - 8.2.2. Өмгөөлөгчийн гаргасан хүсэлтээр;
  - 8.2.3. Монгол Улсын хууль тогтоомжид заасан бусад тохиолдолд.
  - 8.2.4. Домэйн бүртгэлийн үйлчилгээний бүртгэлийн систем нь бүхий л түвшинд нууцлалаар хангагдсан бөгөөд мэдээллийн сан хариуцсан ажилтнууд нууцлалын гэрээтэй ажиллана.

## 9. Домэйн нэрийн талаар маргаан

- 9.1. Домэйн нэрийн эзэмшигчийн эрхийн талаар гарсан аливаа маргаанд бүртгэгчийн зүгээс оролцохгүй ба талуудад WHOIS мэдээллийн сан дахь мэдээллээр хангахаас өөр үүргийг хүлээхгүй.
- 9.2. Домэйн нэр бүртгүүлэгч нь домэйн нэрийг зохих журмын дагуу ашиглаагүй мөн буруугаар болон таны эрх ашгийг ямар нэгэн байдлаар зөрчиж байгаа бол энэ талаар тухайн хэрэглэгчтэй шууд хандаж болно.
- 9.3. Домэйн нэрийн эзэмших эрхийн маргаантай холбоотой асуудлаар талууд Монгол улсын албан ёсны зөвшөөрөлтэй хуулийн фирм, өмгөөлөл, эвлэрүүлэн зуучлах төвөөр дамжуулан гомдлоо барагдуулах үүрэгтэй ба .мон бүртгэлийн үйлчилгээ үзүүлэгч нь ийм төрлийн маргаан татагдан оролцохгүй.
- 9.4. Маргалдагч талууд Монгол улсын шийдвэр гаргах шүүхийн шатны эрх бүхий байгууллагаар маргаанаа таслуулж, эцсийн шатны хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг ирүүлсэн тохиолдолд тухайн домэйн нэрийн эзэмшлийг шүүхийн шийдвэрт дурьдсан этгээдэд шилжүүлнэ.
- 9.5. Домэйн нэрийн эзэмшил, үйл ажиллагаа нь бусдын ашиг сонирхол, хууль ёсны эрх ашиг, оюуны өмчийн болон барааны тэмдгийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэж үзвэл дараах хуулийн фирмд хандаж маргаан үүсгэх, хуулийн зөвлөгөө авах, эвлэрүүлэн зуучлах үйлчилгээнүүдийг авах боломжтой.  
Зохицуулагч тал нь “Ананд энд Батзаяа” хуулийн фирм-тэй хамтран ажиллах гэрээтэй болно.

## 10. Журмын өөрчлөлт

- 10.1. Энэхүү журамд зөвхөн зохицуулагчийн шийдвэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 10.2. Зохицуулагч нь журамд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг нийтэд зарласнаар хүчин төгөлдөр болох ба үүнийг Итгэмжлэгдсэн бүртгэгч, хэрэглэгчид мөрдөн ажиллах үүрэгтэй.
- 10.3. Журманд нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд Үйлчилгээний гэрээний нөхцлүүд шинэчилсэн журмын хүрээнд дагаж өөрчлөгдөнө.